



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 1,839,962,382.00 (нэг тэрбум найман зуун гучин есөн мянга есөн зуун жаран хоёр мянга гурван зуун наян хоёр) төгрөгийн үнэ бүхий 1.39 километр автозамыг Орхон аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000581

C:\2019.07.22 16r huraldaan.docx